

ӨМНӨХ ҮГ

Дэлхий нийтийг хамарсан цар тахал дэгдсэний улмаас эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч, гадаад хамтын ажиллагаа зогссон, өмнө учирч байгаагүй хүндрэл бэрхшээл тулгарсан жил өнгөрч байгаа хэдий ч судалгааны ажлаа зогсолтгүйгээр үргэлжлүүлэн, гарган авсан шинэлэг санаа, шинэ үр дүнгээ олон нийтэд хүргэхээр манай сэтгүүлд өгүүллээ ирүүлсэн эрхэм эрдэмтэн судлаачид та бүхэндээ талархал илэрхийлье.

ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгээс жил бүр эрхлэн гаргадаг “Эрдэм шинжилгээний бүтээл” (Bulletin of Institute of Chemistry and Chemical Technology, BICCT) сэтгүүлийн дугаар 8 буюу 2020 оны дугаар хэвлэгдэн гарч байна. Тус сэтгүүл 2018 оноос Mongolia Journals Online (www.mongoliajol.info) нэгдэн орж, Google Scholar, Dimensions, CNKI Scholar зэрэг хайлтын төрөлжсөн системүүдэд бүртгэлтэй болон, өгүүллүүд нь DOI дугаартай гарах болсноор сэтгүүлийн нэр хүнд өсөж, хэвлэгдсэн өгүүллүүдийн татагдсан тоо жилээс жилд нэмэгдсээр байгаа бөгөөд 2020 оны байдлаар 20287 удаа татагдаж олны хүртээл болжээ. Мөн 2020 онд e-ISSN (2708-1109) дугаар авсанаар албан ёсны эрхтэйгээр (<https://www.mongoliajol.info/index.php/BICCT/>) онлайн хэлбэрээр гарах болсон.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт органик бус хими, материал судлал, биохими, нүүрсний химийн технологи, байгалийн нэгдлийн химийн нийт 5 салбарын 19 эрдэм шинжилгээний өгүүлэл ирж, хөндлөнгийн хянан магадлагаа хийгдсэнээс 12 нь сэтгүүлийн шаардлагыг ханган хэвлэгдэж байна. Хэвлэгдсэн бүтээлүүдийн заримаас товч дурьдвал:

Ч.Номинчулуу нарын судлаачид “*Пивоны дрожджийн гидролизат агуулсан усан суурьтай эмульсийн тогтворжилтын судалгаа*”-аар лецитин агуулсан усан суурьтай эмульс гарган авахад пивоны дрожджийн гидролизатыг нэмж ашиглах нь тэжээллэг чанарыг нэмэгдүүлэхийн сацуу эмульсийн тогтворжилт, антиоксидант идэвхэд эерэгээр нөлөөлж байгааг тогтоожээ. Харин байгалийн нэгдлийн химичид тарималжуулсан хоёр зүйл хунчирын биологийн идэвхт үйлчлэгч нэгдлийн судалгааг хийж, *Монгол хунчирын* үндсэнд полисахарид их хэмжээтэй, харин *Сарьслаг хунчирын* үндсэнд сапонин гликозид илүү агуулагдаж байгааг тодорхойлсон байна. Нүүрсний хими технологийн чиглэлээр судлаачид Могойн голын ордын дээд ангиллын чулуун нүүрсний баяжигдах шинж чанарыг судалж, бага үнстэй нүүрсний баяжмалыг гүн боловсруулалтын чиглэлээр ашиглахад эдийн засгийн ач холбогдолтой гэж дүгнэсэн бол Б.Нямсүрэн нарын судлаачид Тавантолгой, Багануурын нүүрсний ордуудын нүүрсний пиролиззоос үүссэн хийг метанжуулж, харьцуулсан судалгааг хийжээ. Харин Ш.Насанжаргал нар Тавантолгойн нүүрсийг идэвхжүүлэн модификацид оруулж улмаар усан уусмалаас хром (VI) шингээх идэвхийг туршсанаар шингээгч материалаар ашиглах боломжийг судалсан байна. Г.Одонтуяа нарын эрдэмтэд Баянзүрх дүүргийн гүний худгуудын усанд гидрохимийн нарийвчилсан судалгааг явуулж, усны чанарыг үнэлэн эрдэсжилтээс хамааруулан ус чулуулгийн харилцан үйлчлэлийг тодорхойлсон бол Органик бус химичид импортын гал унтраагч хуурай нунтаг бодисыг орлохуйц гал унтраагч шинэчилсэн бэлдмэлийг гарган авч, түүний шинж физик чанар, гал унтраах идэвхийн талаарх судалгааны үр дүнг нэгтгэсэн зэрэг салбар салбарын судлаачдын бүтээлүүд байна.

Манай сэтгүүлд ирүүлсэн өгүүллүүдийн чанарыг сайжруулах, тухайн ажлын шинжлэх ухааны ач холбогдол хийгээд шинэлэг талыг тодруулах, олон нийтэд хүртээмжтэй болгох тал дээр хамтран ажиллаж буй хөндлөнгийн шүүмжлэгч нартаа талархал илэрхийлье.

Улс орны хөгжлийн түлхүүр болсон Монгол улсын шинжлэх ухаан хөгжин цэцэглэх болтугай.

ЕРӨНХИЙ РЕДАКТОР

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР Л.ЖАРГАЛСАЙХАН